


# 2025

ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН ТАЙЛАН



ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛАЖ ЭРҮҮЛ АМЬДРАЛЫГ ХАМТДАА БҮТЭЭНЭ.

## АГУУЛГА

### 01 БИДНИЙ ТУХАЙ



Байгаль орчин,  
нийгэм, засаглалын  
бодлого ба менежмент

Голлох  
үзүүлэлтүүд

### 02 НОГООН ДЭЛХИЙ



Байгаль орчны  
менежмент

Ногоон  
байгууламжийн  
төлөвлөлт

Сав баглаа боодлын  
менежмент

Хог хаягдлын  
менежмент

Эрчим хүч, усны  
хэрэглээ

Уур амьсгалын  
өөрчлөлт

### 03 САЙН САЙХАН ОРШИХУЙ



Эрүүл, инновацлаг  
бүтээгдэхүүн  
үйлдвэрлэл

Олон улсын  
стандартуудыг дагаж  
мөрдөх

Эрүүл амьдралын хэв  
маягийг дэмжих

Тогтвортой ханган  
нийлүүлэлтийн сүлжээ

# 04

## МFC АЖИЛТНУУД



МFC Хүний нөөц

МFC Хөдөлмөрийн  
аюулгүй байдал,  
эрүүл ахуй

МFC Соёл

# 05

## ИЛ ТОД БАЙДАЛ



Эрсдэлийн удирдлага

Засаглал


Хяналт, тайлагнал

# БИЗНЕСИЙН ФИЛОСОФИ



## АЛСЫН ХАРАА

Эх дэлхийгээ хайрлаж, эрүүл амьдралыг хамтдаа бүтээнэ.



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүрээлэн буй орчин, оролцогч талуудаа хүндэлсэн, эрүүл амьдралын хэв маягийг дэлгэрүүлэгч, үнэ цэнэ бүтээгч хамт олон байна.



## ҮНЭТ ЗҮЙЛС

ЭЕРЭГ СОЁЛ  
ИННОВАЦЛАГ БҮТЭЭГДЭХҮҮН  
ОРОЛЦОГЧ ТАЛУУД

# 1

**БИДНИЙ ТУХАЙ**



## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Монос Хүнс ХК нь ард иргэдийнхээ эрүүл мэндийг дэмжих зорилготойгоор Монгол орны хөрсөнд ургасан эмийн ургамлын түүхий эдийг ашиглан амин дэм, эрдэс бодисоор баялаг хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг билээ.

Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн нөхцөл байдлын талаарх судалгаанд дурдагдсан зонхилон тохиолдох өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нэн тустай эрүүл мэндийн хуурай болон шингэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Мөн бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ дамжуулан хэрэглэгчдийнхээ эрүүл мэндийг хамгаалаад зогсохгүй эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зөв дадлыг амьдралдаа хэвшүүлэхэд нь туслахыг онцгойлон анхаарахыг эрмэлздэг.

## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН АМЛАЛТ

### Байгаль орчин

Бид байгалийн нөөцийг зөв зохистой ашиглан үйлдвэрлэл эрхлэхдээ хаягдалгүй үйлдвэрлэлийг бий болгохыг зорьж байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгаж экологийн тэнцвэрт байдлыг хангаж ажиллана.

### Нийгэм

Бид БОНЗ-ын үлгэр жишээ соёлыг хэвшүүлэхэд ажилтан бүрийн оролцоог ханган, зохистой хөдөлмөрийн харилцааг эрхэмлэн, эрүүл аюулгүй, хүнд ээлтэй ажлын байрыг бий болгоход эрмэлзэнэ. Бид зохистой худалдан авалтыг дэмжиж, тогтвортой ханган нийлүүлэлтийг дэмжин ажиллана.

### Засаглал

Монос Хүнс компани нь хариуцлагатай БОНЗ-н тогтолцоог бүрдүүлж, шударга ёс зүйтэй байхыг сурталчлан таниулна.

## 2026 ОНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗОРИЛТУУД

Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогын хүрээнд нэгдсэн удирдлагын тогтолцооны зорилт, шалгуур үзүүлэлтийг жил бүр тодорхойлж, хэрэгжилтийг үнэлж ажиллаж байна.

<p>3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ</p>	<p>8 ЗОХИСТОЙ АЖИЛЛАГАА БА ХӨДӨН МЭТГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ДЭМЖИЛЭЛТ</p>	<p>Компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хэвшүүлж, эрсдэлийг 5%-иар бууруулах</p>
<p>3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ</p>	<p>8 ЗОХИСТОЙ АЖИЛЛАГАА БА ХӨДӨН МЭТГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ДЭМЖИЛЭЛТ</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) шаардлагыг бүрэн хангаж, үйлдвэрийн ослыг тэглэх</p>
<p>13 ӨР АЖИЛЛАГААНЫ ХӨДӨЛӨГ БИГЭСГЭХ</p>	<p>15 ХУУРАЙ ГЭЭРЭН ЭРС-СЭСТЭМЭЭ ХАМГААЛАХ</p>	<p>Компанийн нүүрстөрөгчийн мөрийг (Carbon Footprint) тооцон гаргаж, ялгарлыг бууруулах стратегийн арга хэмжээг төлөвлөх</p>
<p>9 ИННОВАЦИ БОЛОН ДЭМЖИЛЭЛТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ</p>	<p>12 ХАРИУЦЛАГАТАЙ ДЭРГИЙН ДЭМЖИЛЭЛТ</p>	<p>Байгалийн нөөцийн зохистой хэрэглээг үйл ажиллагаандаа хэвшүүлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг өмнөх оны түвшнээс бууруулан, боломжит доод хэмжээнд барихыг зорин ажиллах.</p>

## БОНЗ-ЫН МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Бид байгаль орчин, нийгмийн засаглалын (БОНЗ) хүрээнд тулгарч буй гол асуудлуудыг эрэмбэлж, тэдгээрийн бизнесийн үнэ цэн болон сонирхогч талуудад үзүүлэх нөлөөллийг эрсдэлд суурилан тодорхойлсон.

### БАЙГАЛЬ ОРЧИН



Уур амьсгалын өөрчлөлт



Хүлэмжийн хийн ялгарал



Тойрог эдийн засаг



Ус, хөрс, агаар бохирдол

### НИЙГЭМ



Хүнсний аюулгүй байдал



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй



Эвлэлдэн нэгдэх эрх



Гэрээт ажилтны эрх



Зөрчигдсэн эрх сэргээх



Нийгмийн хариуцлага

### ЗАСАГЛАЛ



Мэдээллийн ил тод байдал



Мөнгө угаалтын эсрэг бодлого




Шүгэл үлээгчийг хамгаалах

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 17 ЗОРИЛТОД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Монос Хүнс компанийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрүүд нь Тогтвортой хөгжлийн 17 зорилтоос 14 зорилттой нь нягт уялдаж, тэдгээрийн хэрэгжилтэд бодит хувь нэмэр оруулж байна.


**3** ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ



3.8 Эрүүл мэндийн үйлчилгээ  
3.9 аюултай химийн бодис, агаар, ус, хөрсний бохирдол  
3.d Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрсдэлийг бууруулах

Ажилчдыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахын зэрэгцээ хүнсний үйлдвэрийн ажилчдын хувьд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг жилд хоёр удаа хийлгэж, эмчийн зөвлөгөө, мэдээллийг тогтмол хүргэдэг.


**6** БАТАЛГААТ УНДНЫ УС АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ



6.1.Баталгаат ундны ус  
6.2 Тэгш хүртээмжтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламж  
6.3 Усны чанар  
6.4 Хэмнэлттэй усны хэрэглээ

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа усны хэмнэлттэй технологийг нэвтрүүлж, ариун цэврийн стандартыг чандлан сахиж, ажиллагсдыг эрүүл, аюулгүй ажлын орчноор хангахад анхаарч ажилладаг.


**4** ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ



4.3 Чанартай техникийн, мэргэжлийн болон дээд боловсрол  
4.7 Тогтвортой хөгжлийн мэдлэг, боловсрол

260 гаруй ажиллагсдын сурч боловсрох нөхцөлөөр ханган, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр ур чадварын матрицаар үнэлгээ хийж, сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг.


**7** СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭВТРҮҮЛЭХ



7.2 Сэргээгдэх эрчим хүч  
7.3 Эрчим хүчний үр ашиг, хэмнэлт

Үйлдвэрийн байгууламжийн гадна талбайн гэрэлтүүлгийг нарны эрчим хүчээр шийдвэрлэсэн ба илүүдэл эрчим хүчийг оффисын хэрэглээнд ашиглаж байна.


**5** ХЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ



5.1 Бүх эмэгтэйчүүд, охидын ялгаварлан гадуурхалт  
5.5 Эмэгтэйчүүдийн манлайлал  
5.a Эмэгтэйчүүдийн эдийн засгийн тэгш эрх

Компанийн нийт ажилчдын 42 хувийг эмэгтэй, 58 хувийг эрэгтэй ажилтнууд эзэлж байна. Гүйцэтгэх удирдлагын түвшинд эмэгтэйчүүд 59 хувийг, эрэгтэйчүүд 41 хувийг бүрдүүлж байгаа бол удирдах зөвлөлийн гишүүдийн 45 хувь нь эмэгтэй, 55 хувь нь эрэгтэй байна.

**8** ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ



8.3 Бичиг, жижиг, дунд бизнесийг дэмжих, зохистой ажлын байр  
8.5 Бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлэлт  
8.8 Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, аюулгүй ажиллах орчин


260 гаруй ажилтныг тогтвортой ажлын байраар хангаж, ажиллах таатай орчин нөхцөлөөр бүрдүүлэн ажиллаж байна.


**9** ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ




9.4 Дэд бүтцийг хөгжүүлж, аж үйлдвэрийн боловсронгуй болгох

Байгальд ээлтэй технологийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, шинжлэх ухааны судалгаа шинжилгээ, инновацыг дэмжих чиглэлээр ажилладаг.

 ТХЗ-Д УЯАЛДАЖ БУЙ БАЙДАЛ

 ТХЗ-Д ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР


**10** ТЭГШ БУС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ



10.2 Эрх тэгш оролцох боломж (нийгэм, эдийн засаг, улс төр)  
 10.3 Ялгаварлан гадуурхлыг халах  
 10.4 Санхүү, цалин, нийгэм хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх  
 10.6 Үр дүнтэй, хариуцлагатай засаглал

Бодлогын хүрээнд бид оролцогч талуудтай харилцах бүхий л үйл ажиллагаандаа хүний эрх, жендерийн эрх тэгш байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хүндэтгэн ажиллахыг зорьдог.


**11** ЗЭГТЭЙ ХОГ ИРГЭДИЙН ОРЛОЦООГ ДЭМЖИХ



11.4 Соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах  
 11.6 Агаарын чанар, хог хаягдлын менежмент  
 11.7 Ногоон болон нийтийн эзэмшлийн талбай

Компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлын 23%-ийг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн.


**12** ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ



12.2 Байгалийн баялагын үр ашигтай хэрэглээ  
 12.4 Химийн бодис, бүх төрлийн аюултай хог хаягдлын менежмент  
 12.5 Хог хаягдлын хэмжээг бууруулах  
 12.6 Компани, аж ахуйн нэгжийн тогтвортой байдал  
 12.8 Тогтвортой хөгжил, байгальд дэлхийтэйгээ зохицон амьдрах амьдралын хэв маягийн талаарх мэдлэг мэдээлэл

Экос усны хуванцарын хэрэглээг 30%-иар бууруулсанаар 2025 оны 154 тонн хуванцар, Энхжин цайны цаас, гялгар уутны хэмжээг бууруулсанаар 2.4 тонн цаасны хог хаягдал байгальд бий болохоос сэргийлж байгаль орчиндоо бодит хувь нэмэр оруулж байна.


**13** УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАЛГАХА



13.2 Цаг уурын өөрчлөлтийн бодлого  
 13.3 Цаг уурын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэрэмжлүүлэх

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахыг зорин ажилладаг ба MFC төгөл байгуулах хөтөлбөрийн эхлэлийг тавин ажиллав.


**15** ХУГАЙ ГАЗРЫН ЭКО СИСТЕМИЙГ ХАМГААЛАХ



15.2 Ойн тогтвортой менежмент  
 15.6 Генетикийн нөөц баялгийн ашиглалт  
 15.7 Ургамлын болон амьтны хулгайн ан

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд бий болсон саарал усыг дахин ашиглаж, дотоодын хэрэгцээнд болон зам талбайн усалгаанд 22%-ийг ашигласан.


**16** ЭНХ ТЭЙВЭН, ШУДАРГА БСЫГ ЦОГЦООХ



16.3 Хүн бүрийг хуулиар хамгаалуулах тэгш боломж  
 16.5 Авилгал, хээл хахууль  
 16.7 Бүх талын оролцоотой, төлөөллийн шийдвэр  
 16.8 Засаглалын үйл ажиллагаа  
 16.b Тогтвортой хөгжлийн буюу үл ялгаварласан бодлого

Бодлогын хүрээнд мэдээллийн ил тод байдал, хуулийн нийцлийг чандлан хангаж, хээл хахууль, авлига болон хувийн ашиг сонирхлоос ангид шударгаар ажиллахыг эрхэмлэдэг бөгөөд шүгэл үлээх журмыг хэрэгжүүлэн, засаглалын кодексийн үнэлгээг жил бүр тогтмол хийдэг.

**17** ХӨГЖИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ



17.4 Өрийн дарамтыг бууруулах  
 17.11 Хөгжиж буй орнуудын экспорт  
 17.16 ТХЗ-д хүрэх хамтын ажиллагаа  
 17.17 Төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн үр дүнтэй түншлэл

Монос Хүнс ХК нь олон улсын болон үндэсний байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, тогтвортой хөгжлийг дэмжих олон талт түншлэлийг бэхжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулсаар байна. Жил бүр дотоодын эмнэлгүүдэд хүүхдийн өрөө тохижуулах санаачилгыг хэрэгжүүлэн, нийгмийн хариуцлагын хүрээнд бодитой ажлуудыг тасралтгүй зохион байгуулж байна. Мөн Монос Хүнс ХК нь Бүгд Найрамдах Киргиз Улсын эм ханган нийлүүлэлтийн "Лекарь" ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээ тус улсад албан ёсоор экспортлон борлуулж эхэлсэн.


ТХЗ-Д УЯЛДАЖ БУЙ БАЙДАЛ  
 ТХЗ-Д ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

## 2025 ОНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### БАЙГАЛЬ ОРЧИН:




### НИЙГЭМ:



### ЭДИЙН ЗАСАГ:



### ЗАСАГЛАЛ:



# 2

## НОГООН ДЭЛХИЙ



## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ

Бид үйл ажиллагаанаас үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарал болон агаар, ус, хөрсний бохирдлыг хамгийн бага түвшинд байлгах бодлого баримтлан, байгаль орчны менежментийн тогтолцоог цогцоор нь хэрэгжүүлдэг.



Монгол Улсын ‘Байгаль орчныг хамгаалах тухай’, ‘Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай’ хууль тогтоомжийн дагуу байгаль орчны төлөв байдлын болон нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, жил бүр холбогдох төрийн байгууллагаар Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг үр дүнтэй дүгнүүлж байна.

## НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ

### “МФС төгөл” төсөл



Бид ажилтнууддаа ногоон байгууламжийн ач холбогдлыг таниулах, байгаль эхтэйгээ ойр нэг өдрийг өнгөрүүлж, хамт олны эерэг уур амьсгалыг бэхжүүлэх зорилгоор 2024 оноос ‘МФС төгөл’ байгуулах санаачилгыг эхлүүлсэн. Уг төслийн хүрээнд Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн болох Баянгол цэцэрлэгт хүрээлэнд мод тарих арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна.



Жил бүрийн хавар, намрын мод тарих өдрүүдийг тохиолдуулан ажилтнууд болон тэдний гэр бүл, хүүхдүүдийг оролцуулсан нээлттэй өдөрлөгүүдийг зохион байгуулж хэвшсэн. 2025 онд бид энэхүү арга хэмжээгээ хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж, өдгөө нийт 530 гаруй модыг тарьж, арчлан ургуулж байна.

### “Эх дэлхийгээ хайрлая - Рашааны эхийг хамгаалах” төсөл



Бид экосистемийн тэнцвэрийг хадгалах, газрын доорх усны нөөцийг хамгаалах зорилгоор ‘Эх дэлхийгээ хайрлая-Рашааны эхийг хамгаалах’ төслийг санаачлан хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд Түргэний аманд байрлах ‘Рашаантын булаг’-ийн эхийг хамгаалах ажлыг амжилттай гүйцэтгэж, холбогдох эрх бүхий байгууллагад хүлээлгэн өглөө. Энэхүү төсөл нь байгалийн ундаргыг хамгаалаад зогсохгүй тухайн бүс нутгийн хүн, малын усан хангамжийн тогтвортой байдлыг хангахад стратегийн чухал ач холбогдолтой юм.

## САВ БАГЛАА БООДЛЫН МЕНЕЖМЕНТ

Монос Хүнс ХК нь сав баглаа боодлын хэрэглээг багасгах, байгальд ээлтэй техник, технологи нэвтрүүлэх зорилтыг амжилттай хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд 'Энхжин' брэндийн эрүүл мэндийн цайны цаас болон гялгар уутны хэрэглээг жилд 8 тонноор хэмнэсэн. Мөн 2024 оноос эхлэн 'Экос' зөөлөн усны савлагаанд 29/25 хэмжээтэй нимгэн бөглөө ашиглаж эхэлснээр хуванцрын орцыг 30 хувиар бууруулж, зах зээлд хамгийн нимгэн савлагаатай бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэв. Эдгээр оновчтой шийдлүүдийн үр дүнд 2025 онд нийт 154 тонн хог хаягдал байгальд гарахаас урьдчилан сэргийлж чадсан байна.



*Овор хэмжээг багасгахад илүү хялбар болов.*

MFC 2.0 нэгдсэн үйлдвэрийн төслийг амжилттай хэрэгжүүлснээр "Экос" усны хуванцрын хэрэглээг **30%-иар бууруулж, 154 тонн хуванцар хаягдлаас сэргийлээд байна.**

Мөн үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын хүрээнд хэрэглэгчдийг хог хаягдлын зөв зохистой ангилан ялгахад уриалан сурталчлах зорилгоор Экос усны савны шошгод "шошгоо савнаас салгаж хогоо ангилан хаяна уу!" тэмдэглэгээ байршуулсан ба Экос усны савыг буцаан авах, хэрэглэгчдийг урамшуулах хөтөлбөрийг тогтмол зохион байгуулдаг.



Цаасны хэрэглээг  
45% бууруулав.



Нэгж бүтээгдэхүүний гялгар уутны  
хэрэглээг 90% бууруулав.

*"Энхжин" цайны савлагааг шинэчилсэнээр 2,4 тонн хог хаягдлаас сэргийллээ.*


## ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Үйлдвэрлэл, үйл ажиллагааны бүхий л нэгж хэсэгт хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах нөхцөлийг 2024 оноос бүрдүүлж, хэмжилт, бүртгэл, хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн. Бид хог хаягдал дахин боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд 2024 онд нийт хог хаягдлын 10 хувийг (хуванцар, хатуу картон, зөөлөн гялгар уут, ургамлын шаар болон тос г.м) дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж, 0.5 хувь болох аюултай хог хаягдлыг зориулалтын дагуу устгуулсан. Харин 2025 онд дахин боловсруулалтад тушаасан хог хаягдлын хэмжээг 23 хувьд хүргэж өсгөлөө.

2025 онд энгийн хог хаягдал 76%, дахин боловсруулсан хог хаягдал 23%, аюултай хог хаягдал 1%-ийг тус бүр эзэлж байна. Эх үүсвэр дээр нь ангилан ялгалт хийдэг ба нийт дахин боловсруулсан хаягдал хуванцар 24%, хатуу картон 41%, гялгар уут 12%, ургамлын хаягдал 23%-ийг тус тус эзэлж байна.

### ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ

Ахуйн хаягдал	Аюултай хаягдал	Хуванцар хаягдал	Хатуу картон	Гялгар уут
<b>125,7тн</b>	<b>1,4тн</b>	<b>8,9тн</b>	<b>15,3тн</b>	<b>4,5тн</b>



Компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгадаг ба **дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэн ажилладаг.**

## ЭРЧИМ ХҮЧ, УСНЫ ХЭРЭГЛЭЭ

### Усны хэрэглээ



Усны зохистой хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор нийт усны хэрэглээний 22%-ийг дахин ашигласан ба ариутгал цэвэрлэгээ, ахуйн хэрэглээнд болон гаднах байгууламжийн зам талбайн усалгаанд дахин ашигласан байна.

Үйлдвэрлэлийн төлөвлөлтийг боловсронгуй болгож, бүтээмжийг 2,5 дахин нэмэгдүүлснээр усны зохистой хэрэглээг бүрдүүлж, ус дахин ашиглалт нэмэгдэж, нөөцийн зохистой менежмент сайжирсан. Хэсэг бүр дээрх тогтмол хяналтын үр дүнд усны хэрэглээг 4%-р бууруулан ажиллалаа.

2024

2025

НЭГЖ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХЭД  
ЗАРЦУУЛСАН УСНЫ ХЭМЖЭЭ

-14%

-16%

### Эрчим хүчний хэрэглээ



Үйлдвэрлэлийн төлөвлөлтийг сайжруулан, бүтээмжийг 2,5 дахин нэмэгдүүлснээр эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг бүрдүүлэн, 15%-ийн хэмнэлт хийн эрчим хүчний үр ашиг нэмэгдэж, сэргээгдэх эх үүсвэрийн хэрэглээ тогтмол есөх суурь бүрдсэн.

2024

2025

НЭГЖ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХЭД  
ЗАРЦУУЛСАН ЦАХИЛГААНЫ ХЭМЖЭЭ


-46%

-26%

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛАХ

### “MFC EAST LOG” ЗҮҮН БҮСИЙН АГУУЛАХЫН БАРИЛГЫН ТӨСӨЛ

MFC 2.0 нэгдсэн үйлдвэрийн төслийг амжилттай хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн хүчин чадлаа 2,5 дахин нэмэгдүүлсэн билээ. Үүний үр дүнд бид зах зээлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, эрэлтийг бүрэн хангах нөхцөл бүрдэж, бүтээгдэхүүн хадгалах олон улсын стандартад нийцсэн “MFC EAST LOG” 2,730м<sup>2</sup> агуулахын барилгын ажлыг 2025 онд эхлүүлэв.



#### Ложистикийн менежмент

Түгээлтийн сүлжээг оновчтой төлөвлөж, ложистикийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх;

#### Нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах

Түгээлтийн автомашинуудын туулах зам, түлш шатахуун зарцуулалтыг бууруулж, тээвэрлэлтээс үүдэлтэй агаарын бохирдлыг багасгах;

#### Сэргээгдэх эрчим хүч

Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж ашиглаж, хэрэгцээт цахилгааныг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс бүрдүүлэх;

#### Эрчим хүчний хэмнэлт

Барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах дэвшилтэт шийдлүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.



Ложистикийн үйл ажиллагааг сайжруулах, оновчтой түгээлтийг төлөвлөх замаар нэгж түгээлтийн түлшний хэрэглээг бууруулах, цахилгааны хэрэглээг сэргээгдэх эрчим хүчээр хангах, дулаан алдагдал багатайгаар төлөвлөсөн.

# 3

## САЙН САЙХАН ОРШИХУЙ

3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ  
ДЭМЖИХ



9 ИННОВАЦИ БОЛОН  
ДЭД БҮТЦИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ



10 ТЭГШ БУС  
БАЙДЛЫГ  
БУУРУУЛАХ



12 ХАРИУЦЛАГАТАЙ  
ХЭРЭГЛЭЭГ  
ДЭМЖИХ



17 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ  
ТҮНШЛЭЛИЙГ  
БЭХЖҮҮЛЭХ



## ЭРҮҮЛ, ИННОВАЦЛАГ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ


Эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй хуурай болон шингэн хүнсний 12 брэндийн 72 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

Бид эрүүл мэндийг дэмжих хүнс болон эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ орчин үеийн шинжлэх ухааны ололт болон уламжлалт анагаах ухааны мэдлэгийг хослуулдаг. Нарийн судалгаа, шинжилгээнд үндэслэн чанарын баталгаатай, эрүүл бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн гарт хүргэхийг зорин ажиллаж байна.

### Ус, ундаа



### Эрүүл мэндийн бүтээгдэхүүн



### Хүүхдийн бүтээгдэхүүн



### Цай



## ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУДЫГ ДАГАЖ МӨРДӨХ



### Баталгаажсан стандартууд

Хэрэглэгчдэдээ олон улсын түвшний чанарын баталгааг амлаж, хүнсний аюулгүй байдлыг хамгийн дээд түвшинд хангах зорилгоор FSSC 22000 (Хүнсний аюулгүй байдал), ISO 14001 (Байгаль орчны удирдлагын тогтолцоо), ISO 9001 (Чанарын удирдлагын тогтолцоо), ISO 17025 (Лабораторийн чадавх) зэрэг олон улсын стандартуудыг амжилттай нэвтрүүлж, олон улсын SGS (Швейцар) байгууллагын магадлан аудитад гурав дахь жилдээ амжилттай хамрагдаж, баталгаажуулалтаа бататгалаа.



**FSSC 22000**

Хүнсний аюулгүй  
байдлын тогтолцоо  
FSSC 22000



Чанарын удирдлагын  
тогтолцоо  
ISO 9001



Байгаль орчны  
удирдлагын  
тогтолцоо ISO 14001



Лабораторийн  
итгэмжлэл  
ISO 17025



## ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙГ ДЭМЖИХ



### “BCH Knights” бар

Бид спортыг дэмжих, залуучуудыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягт уриалах зорилгоор ‘Экос’ брэндээрээ дамжуулан Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Үндэсний дээд лигийн ‘BCH Knights’ багтай 4 дэх жилдээ түншлэн ажиллаж байна. Энэхүү урт хугацааны хамтын ажиллагааны хүрээнд бид тамирчдын эрч хүчийг тэтгэж, амжилтын төлөөх алхам бүрд нь хамт байж, үндэсний спортын хөгжлийг тууштай дэмжсээр ирлээ.



### “Hunters FC” бар

Эрүүл мэнд, идэвхтэй амьдралын хэв маягийг эрхэмлэгч ‘Экос’ брэнд хөлбөмбөгийн ‘Hunters’ багийн албан ёсны дэмжигчээр ажиллаж, тамирчдын амжилт бүрд хамт байлаа. Бид тамирчдын талбай дээрх тэмцэл, багийн эв нэгдэл, эрч хүчтэй мөч бүрийг дэмжихийг зорин, үндэсний спортын хөгжилд бодит хувь нэмрээ оруулсаар байна.



### “Их дуулга” тэмцээн

Бид дэлхийн чансааны оноо олгох өндөр зэрэглэлийн ‘Улаанбаатар Их Дуулга 2025’ олон улсын жүдо бөхийн тэмцээнийг ‘Экос’ брэндээрээ ивээн тэтгэж, спортын хөгжилд бодит хувь нэмэр орууллаа. Энэхүү түншлэл нь залуу тамирчдын оролцоог дэмжихээс гадна олон нийтэд эрүүл амьдралын хэв маягийг сурталчлан түгээхэд онцгой ач холбогдолтой үйл явдал болов.




## Mongolian Fact Check Center

Бид “Баримтад нэгд” аяныг дэмжиж, цахим орчинд тархаж буй эрүүл мэндийн тухай хуурамч болон дутуу мэдээллийг баримтаар нягтлан, буруу мэдээллийн тархалтыг хязгаарлах, улмаар хэрэглэгчдэд бодит бөгөөд үнэн зөв мэдээлэл хүргэхэд хувь нэмэр оруулан ажиллалаа. Бид баримтад суурилсан нийгмийн хэлэлцүүлгийг дэмжих замаар иргэдийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэхийг зорив.



## ХӨСҮТ – Тусгай хэрэгцээт хүүхдийн эмчилгээний өрөө

Манай компани нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхдэд ээлтэй, аюулгүй, ая тухтай орчныг бий болгоход тогтмол анхаарч ажилладаг. Бид ХӨСҮТ-ийн Агаар дуслын халдварын тасагт “Тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан эмчилгээний өрөө”-г тохижуулан хүлээлгэн өглөө. Энэхүү өрөө нь хүүхдүүд аав, ээж, асран хамгаалагчийнхаа хамт цагийг өнгөрүүлэх боломжтойгоор зохион байгуулагдсан бөгөөд зөвхөн эмчилгээний бус, сэтгэл санааг дэмжихэд чиглэгдсэн. Олон улсын стандартад нийцсэн ариун цэврийн өрөө, банн, халдваргүйжүүлэх кварцын гэрэл болон бусад тохижилт нь бие болон сэтгэл санаагаа тайвшруулснаар эмчилгээнд түлхэц болох боломжтой боллоо.



## Эрүүл мэндийн өдөрлөг, арга хэмжээ

Монос Хүнс ХК нь хэрэглэгчдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор эрүүл мэндийн өдөрлөг, сургалт, зөвлөгөө мэдээллийг мэргэжлийн эмч төлөөлөгчдөөр дамжуулан тогтмол хүргэж байна. Тухайлбал, 2025 онд нийт 102 удаагийн сургалт, зөвлөгөөг зохион байгуулж, 2050 гаруй хэрэглэгчид эрүүл мэндийн мэдлэг олгох үйлчилгээг амжилттай үзүүллээ.




## ТОГТВОРТОЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ

Компанийн хувьд жил бүр дотоодын бэлтгэн нийлүүлэгчийн тоо өссөн үзүүлэлттэй байдаг. 2025 онд нийт 366 бэлтгэн нийлүүлэгч байгаагаас дотоодын бэлтгэн нийлүүлэгч нь 85%, гадаадын бэлтгэн нийлүүлэгч 15%-ийг эзэлж байна. Худалдан авалтын мөнгөн дүнгээр харьцуулахад дотоодын худалдан авалт 38%-ийг эзэлж байна.



Худалдан авалтын дүн



Бэлтгэн нийлүүлэгчийн тоо

Бараа, бүтээгдэхүүн, түүхий эд нийлүүлэх ААН, иргэдийг сонгон шалгаруулахдаа үнэ, чанар, санхүүгийн чадавх, татварын өр, тусгай зөвшөөрөл (шаардлагатай тохиолдолд), тогтвортой үйл ажиллагаа, баталгаа зэрэг үзүүлэлтийг авч үздэг. Бэлтгэн нийлүүлэгчдийн сонгон шалгаруулалтад босго үнээс хамааруулан харьцуулсан судалгаа хийж (бараа, ижил, үйлчилгээний үзүүлэлт, стандарт, чанар, туршлага, хугацааны урсгал зардал, суурилуулалтын зардал, гүйцэтгэлийн хугацаа, баталгааны нөхцөл, даатгалын нөхцөл, төлбөрийн нөхцөл, хамтран ажиллаж ирсэн байдал, гүйцэтгэлийн түүх) сонгодог.

### Бэлтгэн нийлүүлэгчийн үнэлгээ

Бэлтгэн нийлүүлэгчийг үнэлэх, гүйцэтгэлд хяналт хийх журмын хүрээнд 2025 онд **сав баглаа, түүхий эд материал болон бараа, ажил үйлчилгээний чиглэлийн 29 бэлтгэн нийлүүлэгчдэд**, бэлтгэн нийлүүлэгчийн үнэлгээ болон гүйцэтгэлийн үнэлгээг сар бүр тогтмол хийдэг бөгөөд үнэлгээний дундаж үзүүлэлт 98.8% байна. Үйл ажиллагааны чиглэл, хүнсний аюулгүй байдал, байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд зөвлөн, туслах, дэмжлэг үзүүлэх үйл ажиллалааг хэрэгжүүллээ.

### Бэлтгэн нийлүүлэгчийг халамжлах хөтөлбөр


Бид бэлтгэн нийлүүлэгчийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд жил бүр уламжлалт уулзалтыг зохион байгуулдаг. Энэхүү арга хэмжээгээр дамжуулан компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн процессыг танилцуулахаас гадна чанарын удирдлага, олон улсын стандарт болон БОНЗ-ын (Байгаль орчин, нийгэм, засаглал) үзэл баримтлалын талаар нэгдсэн сургалт, мэдээллийг хүргэж ажилладаг.



## САНАЛ ГОМДЛЫН МЕНЕЖМЕНТ

### Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа

Экос зөөлөн ус, Витос Цэнэг, Эко уусдаг цай, Тайлагч зэрэг голлох брэндүүдийн хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг сар бүр тогтмол хөндлөнгийн байгууллагаар хийлгэдэг ба 2025 оны хэрэглэгчийн сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 88% тай байна.



Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, сар бүрээр

### Бүтээгдэхүүний санал гомдлын шийдвэрлэлт



Хүнсний аюулгүй байдлын

3/3



Чанарын аюулгүй байдлын

10/10

2025 онд бүртгэгдсэн нийт 13 гомдлыг (Хүнсний аюулгүй байдлын 3, Чанарын аюулгүй байдлын 10) чанарын удирдлагын тогтолцооны дагуу нарийвчлан судалж, үндсэн шалтгааныг тогтоолоо. Бид гомдлын дагуу мэдээллийг хэрэглэгчдэд хурдан шуурхай хариу хүргэснээр **нийт гомдол шийдвэрлэлтийн түвшинг 100%-д хүргэж ажиллав**. Энэ нь манай компанийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хандах хариуцлагын баталгаа юм.

# 4

## МҮС АЖИЛТНУУД



## MFC ХҮНИЙ НӨӨЦ

НИЙТ АЖИЛТАН **267**ЭРЭГТЭЙ  
**157**ЭМЭГТЭЙ  
**110**УДИРДАХ АЖИЛТАН **17**  
ҮҮНЭЭС ЭМЭГТЭЙ **10**ТУСГАЙ  
ХЭРЭГЦЭЭТ  
АЖИЛТНЫ ТОО **7**

## BABY BOOMERS

2024 2.7%  
**2025 2.6%**

## GEN X

2024 17.6%  
**2025 15.4%**

## MILLENNIAL

2024 60.7%  
**2025 51.7%**

## GEN Z

2024 28.2%  
**2025 30.3%**АЖИЛТНЫ  
СЭТГЭЛ  
ХАНАМЖ2024 **78.2%**2025 **77.2%**

▼ 1%

АЖИЛТНЫ  
ЭНГЭЙЖМЕНТ2024 **77.3%**2025 **77.4%**

▲ 0.1%

ДУНДАЖ АЖИЛЛАСАН ЖИЛ **3.7 ЖИЛ**

## МФС ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Ослыг тэглэх, эрүүл аюулгүй ажлын байр бий болгох, хүн бүр ХАБЭА манлайлагч байх зорилтыг дэвшүүлж, нийт ажилтны сургалт, ажлын байрны үзлэг шалгалт, галын анхан шатны багаж хэрэгсэл, анхны тусламжийн цэгийг байнга шалган, үйл ажиллагааны онцлогоос хамаарсан онцгой байдлын сургалт, замын цагдаагийн сургалт, улаан загалмайн сургалт дадлагыг төлөвлөгөөний дагуу хийж байна.

Мөн ХАБЭА орон тооны бус байнгын зөвлөлийг ажиллуулж, Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх байнгын комиссыг ажиллуулж осол, осолд дөхсөн тохиолдлыг судлан бүртгэж, осолд дөхсөн тохиолдлуудад дүн шинжилгээ хийж бодит ослоос урьдчилан сэргийлэх ажлуудыг төлөвлөн, хэрэгжүүлж ажиллаж байна.

### СУРГАЛТ

31 УДАА

ХАМРАГДАСАН НИЙТ  
АЖИЛТНЫ ТОО

617

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ

2025

ХАМРАГДАСАН НИЙТ  
АЖИЛТНЫ ТОО

237

### ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН АЖИЛЧДЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ

жилд 2 УДАА


ХАМРАГДСАН АЖИЛТНЫ ТОО 338

ДАВХАРДСАН ТООГООР

**ХАБЭА**-н чиглэлээр хэд хэдэн төрлийн хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тухайлбал:



Дархлаажуулалтыг дэмжих хөтөлбөр



Ажлын байрны аюулыг мэдээлэх аян

## АЖИЛЛАХ ОРЧИН, ХАЛАМЖ:

Компани ажилтнуудын ажил амьдралын тэнцвэр, сурч хөгжих боломжийг дэмжих зорилгоор

- Ердийн цагийн хуваарь,
- Сонголттой цагийн хуваарь,
- Богиносгосон цагийн хуваарь
- Уян хатан гэсэн 4 төрлийн ажлын цагийн хуваарьтай.

### Нэмэлт халамж

Цалинтай 4 өдрийн чөлөө

Ажилтан бүр хувьцаа эзэмшигч

Бяцхан үрсийг дэмжих хөтөлбөр

Хоол, унааны хөнгөлөлт

Эрүүл мэндийн даатгал, үзлэг


Хуримтлалын багц

Утасны хөнгөлөлт

Гэнэтийн ослын даатгал

Дотоод, гадаадын сургалт, хөгжлийн боломж


Гүйцэтгэл, бүтээмж, зорилтын урамшуулал



**АЖИЛЛАХ ОРЧИН**



## АЖИЛТНУУДАД ЧИГЛЭСЭН ХӨТӨЛБӨРҮҮД



2025 оны 09 сарын 17

### Монос Бахархалын өдөр


Монос Хүнс ХК-ийн “Монос Бахархлын өдөр” нь жил бүрийн 9 сарын 17-нд уламжлан болгон зохион байгуулдаг. Тухай өдөр нь өндөр бүтээмжтэй өдөр байх зорилт тавин өдрийн гүйцэтгэлээ хэмжиж, дотооддоо мэдээлэл хүргэдэг. Энэ нь байгууллагын нэр хүнд, үнэт зүйлсийг ажилтнуудад таниулах, хамт олны бахархлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал арга хэмжээ юм.



2025 оны 03 сарын 15

### 8/18 арга хэмжээ

Монос Хүнс ХК нь Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон Монгол цэргийн баярыг тохиолдуулан жил бүр уламжлал болгон “8/18” арга хэмжээг зохион байгуулдаг. Энэ нь хамт олны эв нэгдэл, ажиллах уур амьсгалыг сайжруулахад эерэг үр нөлөө үзүүлдэг.



Долоо хоног бүр

### Спорт заал

Урлаг, спортын арга хэмжээг жилд тогтмол зохион байгуулдаг ба ажилтны эрүүл мэнд, хамт олны уур амьсгалыг сайжруулах зорилгоор спорт заалтай гэрээ байгуулан, ажилтнууд 7 хоног бүр тогтмол спорт зааланд чөлөөт цагаа өнгөрөөдөг.



2025 оны 12 сарын 18-19

### Спорт арга хэмжээ

Монос Хүнс ХК-ийн спортын наадам Спортын арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг ба энэ жил “Хамтдаа илүү хүчтэй” уриан дор болж өнгөрсөн юм. Энэ удаагийн спортын их наадамд бүх албадуудын 260 гаруй ажилтнуудыг хамруулсан ба нийт зургаан багт хуваагдаж, зургаан төрлөөр 36 багц медалийн төлөө оюун ухаан, хурд хүчээ уралдуулан өрсөлдлөө.



Улирал бүр

### Шинэ ажилтныг чиглүүлэх хөтөлбөр

Монос Хүнс ХК-ийн шинэ ажилтнуудаа компани болон группийн ХОЁР удаагийн чиглүүлэх сургалтанд хамруулдаг бөгөөд энэхүү сургалтаар компанийн хэмжээнд дагаж мөрдөх хэм хэмжээ, компанийн үүсэл түүх, одоо болон ирээдүйн зорилго, зорилт, төслүүд, нэвтрүүлсэн чанарын стандартууд, үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнүүдийн дэлгэрэнгүй танилцуулга болон дотооддоо карьер өсгөх боломж зэрэг мэдээллүүдийг ажилтанд өгдөг.

## СУРГАЛТ, ХӨГЖИЛ:

Монос Хүнс ХК нь сургалт хөгжлийн журмыг мөрдлөг болгон жил бүр ажилтнуудын хувийн хөгжлийн төлөвлөгөөг гаргуулан авч, ур чадварын матрицаар ажилтанд шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлон, бүтэн жилийн гадаад болон дотоод сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу болон цаг үеийн шаардлагатай сургалтуудыг зохион байгуулан ажилладаг.

### Сургалтын төлөвлөгөөг

- Ерөнхий ур чадварын,
- Мэргэжлийн ур чадварын,
- Нарийн мэргэжлийн сургалт гэж ангилан боловсруулдаг.

Ажилтнуудаа Монгол улсын томоохон байгууллагуудын сургалтанд хамруулахаас гадна, гадаад улсад зохион байгуулагдах сургалт, семинар, форум, экспод жил бүр хамруулдаг.



### СУРГАЛТЫН ТОО 110

ХАМРАГДАСАН НИЙТ АЖИЛТНЫ ТОО

2104

СУРГАЛТАД ХАМРАГДСАН ЦАГ

230

СУРГАЛТЫН НИЙТ ЗАРДАЛ

21.9 САЯ ₮



Компанийн ажилчдын сургалт хөгжлийн дэмжих хөтөлбөрийн хүрээнд гурван эмч төлөөлөгч нарыг Эм зүйн шинжлэх ухааны сургуульд “Эм зүйн” бакалавр мэргэжлээр суралцуулж байна.

## MFC СОЁЛ

### “MFC Retreat” арга хэмжээ

Ирэх оны бизнесийн гол зорилтуудаа тодорхойлдог Retreat арга хэмжээг MFC RETREAT CATALYST 2026 нэртэйгээр зохион байгуулсан ба 2026 онд хэрэгжүүлэх гол стратеги төлөвлөгөө, эрсдэлийн үнэлгээ, бууруулах арга хэмжээнүүдийг тодорхойлсон байна. БОНЗ-ийн бодлогыг нутагшуулан оролцогч талуудаа татан оролцуулах, ажилтнуудын тогтвортой ажил эрхлэлтийг бодлогоор дэмжих, ажилтны бүтээмжийн нэмэгдүүлэх чиглэлээр чадавхжуулах сургалтуудад хамруулах зэрэг гол зорилтууд тодорхойлсон.

### “MFC харилцагчийг дэмжих” хөтөлбөр


Бэлтгэн нийлүүлэгч болон харилцагчийн өдөрлөгийг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд энэ хүрээнд ‘ТОП 100’ харилцагчтай уулзаж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцах аялал зохион байгуулав.

### “MFC Tour” үйлдвэрийн аялал

Монос Хүнс ХК нь “MFC Tour” арга хэмжээг 2025 оноос зохион байгуулж эхэллээ. Энэхүү арга хэмжээний гол зорилго нь компанийн стратегийн чухал төсөл болох MFC 2.0 төслийн үр дүн, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн шинэчлэл болон компанийн өдөр тутмын үйл ажиллагааны онцлогийг танилцуулахад чиглэсэн арга хэмжээ юм. 2025 онд 300 гаруй зочид компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцлаа.

MFC RETREAT 2025  
HIGHWAY 

 CATALYST  
MFC RETREAT



## “MFC News” дотоод видео контент

Монос Хүнс ХК нь ажилтнуудын дотоод мэдээллийн хүртээмж, байгууллагын уур амьсгал, харилцаа холбоог сайжруулах зорилгоор “MFC News” нэртэй видео цуврал контентыг дотоод групптээ тогтмол байршуулж байна.




## “MFC од” баярын хурал

Жил бүр Монос Хүнс ХК-ийн хамт олон Баярын хурал зохион байгуулж, өнгөрсөн оны амжилт ололтоо дүгнэж, ирэх оны зорилттой танилцаж, тухайн жилийн шилдэг, өндөр бүтээмж бий болгосон ажилтнуудаа тодруулан MFC Од тэмдгээр шагнаж урамшуулдаг.



## “MFC FAMILY” цуврал контент

“MFC Family” нь Монос Хүнс ХК-ийн соёл, үнэт зүйлсийг ажилтнуудынхаа бодит жишээн дээр тулгуурлан түгээж, байгууллагын дотоод уур амьсгал, ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд бодитой үр нөлөөтэй юм.



# 5

ИЛ ТОД БАЙДАЛ




# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Монос Хүнс ХК нь тогтвортой өсөлт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор эрсдэлийг системтэйгээр илрүүлэх, үнэлэх, удирдах олон улсын шилдэг туршлагад нийцсэн аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

## 2025 оны эрсдэлийн үнэлгээ


2025 оны стратегийн Annual Retreat арга хэмжээний хүрээнд нийт 68 эрсдэл тодорхойлогдож, тус бүрд нь хариу арга хэмжээ боловсруулан холбогдох алба нэгжүүдийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус арга хэмжээ нь байгууллагын стратегийн зорилтуудтай уялдсан эрсдэлийн зураглал гаргах, нөөц бололцоог оновчтой хуваарилах, боломжийг эрт илрүүлэн ашиглах чухал ач холбогдолтой юм.

## Эрсдэлийн удирдлагын тогтолцоо




Энэхүү тогтолцоог хэрэгжүүлэх хүрээнд компанид **эрсдэлийн удирдлагын баг** болон **дотоод аудитын тогтолцоо** тогтмол ажиллаж буй юм. Мөн жил бүр Annual Retreat стратегийн арга хэмжээг зохион байгуулж эрсдэлийг тасралтгүй хянаж, сайжруулсаар байна.

## Эрсдэлийн ангилал ба үнэлгээ



### Эрсдэлийг нөлөөллийн түвшнээр



### Эрсдэлийн хариу арга хэмжээ

Бид эрсдэлээс зайлсхийх, эрсдэлийг бууруулах, эрсдэлийг шилжүүлэх/даатгал гэрээт зохицуулалт/, нөөц төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийг хүлээн зөвшөөрөх зэрэг хариу арга хэмжээг авч ажиллаж байна.

**Эдгээр арга хэмжээг алба, нэгжийн түвшинд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж байна.**

2025 оны стратегийн Annual Retreat арга хэмжээний хүрээнд нийт 68 эрсдэл тодорхойлогдож, тус бүрд нь хариу арга хэмжээ боловсруулан холбогдох алба нэгжүүдийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус арга хэмжээ нь байгууллагын стратегийн зорилтуудтай уялдсан эрсдэлийн зураглал гаргах, нөөц бололцоог оновчтой хуваарилах, боломжийг эрт илрүүлэн ашиглах чухал ач холбогдолтой юм.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Тайлангийн хугацаанд Монос Хүнс ХК-ийн ТУЗ нь ердийн 6, хараат бус 5, нийт 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллажээ. Энэ хугацаанд ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Баттогтох өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, компанийн тухай хуульд зааснаар хараат бус гишүүний шаардлагыг хангасан ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтыг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос /НДХ/ нээлттэйгээр зарласнаар 63 хүний хүсэлт, анкетад тулгуурлан ТУЗ-ийн дэргэдэх НДХ эхний, 2025 оны 11-р сарын 12-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар эцсийн сонгон шалгаруулалтыг тус тус хийн ТУЗ-ийн гишүүнийг түр орлох гишүүнээр Б.Бат-Уулыг томилсон байна.

### ТУЗ-ийн хурал

2025 онд Монос Хүнс ХК-ийн ТУЗ нь ээлжит хурал 4 удаа, ээлжит бус хурал 5 удаа хийхдээ танхимаар 4, цахимаар 3, эчнээ санал хураалтаар 2 удаа тус тус зохион байгуулж, эдгээр хурлаар нийт 35 асуудлыг хэлэлцэн, 27 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд Гүйцэтгэх захирал, удирдлагын багийн ажилтнуудад 40 үүрэг даалгавар, зөвлөмжийг өгч, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллав.

### 2025 оны ТУЗ-ийн онцлох шийдвэрүүд

2025 оны 2-р сарын 19-ны ээлжит хурлаар компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт, ногдол ашиг хуваарилах асуудал, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов, мөн “Шүгэл үлээх журам”-ыг хэлэлцэн, холбогдох тогтоол, шийдвэрийг гаргав. 2025 оны 8-р сарын 7-ны ээлжит хурлаар Гүйцэтгэх удирдлагаас танилцуулсан Улаанбаатар хотын зүүн үйлдвэрийн бүсэд хэрэгжүүлэх “MFC EAST LOG” төслийн хөрөнгө оруулалтыг дэмжиж шийдвэрлэв. Оны эцсийн байдлаар төслийн хэрэгжилт 38%-тай байгаа бөгөөд 2026 оны эхний хагас жилд багтаан төслийг ашиглалтанд оруулахаар төлөвлөн төслийн баг ажиллаж байна. Мөн тус хурлаар ТУЗ-ийн дэргэдэх хороодын бие даасан журмыг хэлэлцүүлж тогтоолоор батлав.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН:


Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээг тогтмол хийдэг бөгөөд уг үнэлгээг ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг, тайлагнал, мэдээллийн ил тод байдал, аудит, хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал, оролцогч талуудын эрх ашиг, компанийн соёл, хувьцаа эзэмшигчдийн эрх зэрэг зарчмуудын хүрээнд хийж, **96%-ийн үнэлгээ авсан.**

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ:

ҮЦБЖ дагуу Монголын Хөрөнгийн Бирж, компанийн вэб хуудаст 2025 онд дараах мэдээллийг байршуулаад байна.

## ХӨРӨНГИЙН БИРЖ ВЭБ ХУУДАСТ


- Улирлын болон жилийн эцсийн санхүү тайлан
- Хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан
- БОНЗ-ын үнэлгээний хураангуй тайлан
- КЗК-ын хэрэгжилтийн тайлан
- ХЭЭХ-ын зар, мэдэгдэл
- ХЭЭХ-аас гарсан шийдвэр
- ТУЗХ-ын шийдвэр, тэмдэглэл
- КЭБАТ-ы мэдээлэл



Монголын  
Хөрөнгийн Бирж

## КОМПАНИЙН ВЭБ ХУУДАСТ

- Хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан
- БОНЗ-ын үнэлгээний тайлан
- -КЗК-ын хэрэгжилтийн тайлан
- ХЭЭХ-ын зар, мэдэгдэл
- ХЭЭХ-аас гарсан шийдвэр
- ТУЗХ-ын хурлын товч мэдээлэл
- ТУЗ гишүүд дэлгэрэнгүй мэдээлэл
- ТУЗ-ийн журмууд



Монос Хүнс

ТӨВ ОФФИС:

Сонсголонгийн зам гудамж 32/3 тоот,  
Үйлдвэрийн баруун бүс, БГД, 20-р хороо,  
Улаанбаатар, 16103, Монгол Улс



[www.monosfoods.mn](http://www.monosfoods.mn)



[Foods@monos.mn](mailto:Foods@monos.mn)



MonosFoods



976-7777-3525